



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 111

Амардалай

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага
худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, сумын 2022 оны "Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө"-г үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Дэлгэрцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 07-р хуралдааны 04 дугаар тогтоолын дагуу Дэлгэрцогт сумын нутаг дэвсгэрт 3 байршлын нийт 3084 м.кв (0.3084 га) газар, мөн тус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн 13 дугаар тогтоолын дагуу Дэлгэрцогт сумын нутаг дэвсгэрт 1 байршлын 3000 м.кв (0.3 га) газар нийт 4 байршлын газрыг хавсралтанд заасан зориулалтын дагуу тус тус газар эзэмших эрхийн дуудлага худалдааг цахимаар дахин зохион байгуулсугай.

2. Дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлэх газрын хэмжээ, зориулалт байршил, хугацаа, дуудлага худалдааны анхны үнэ, дуудлага худалдаа явуулах өдрийг хавсралтаар баталсугай.

3. Дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулж, дуудлага худалдааны зар мэдээг www.mle.mn газрын цахим биржид болон мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй зарлан явуулсугай.

4. Дуудлага худалдаа явуулах хугацаа, тавигдах шаардлага нөхцлүүдийг тодорхойлон олон нийтэд зарлан мэдэгдэж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

4880200507